

**“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 09 сарын 30-ны өдөр

№ 04/25

Улаанбаатар хот

Давуу эрхийн хувьцаа гаргах эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дах заалт, 35 дугаар зүйлийн 35.9 дэх заалт, Компанийн дүрмийн 3 дугаар хэсгийн 3.13.1 дэх заалт болон 2025 оны 09 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж давуу эрхийн хувьцааг 1000 /нэг мянга/ ам.долларын нэгжийн үнэтэйгээр 10,000 /арван мянга/ ширхэг хүртлэх тоогоор гарах эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
2. Компанийн давуу эрхийн хувьцаа гаргах хүрээ, давуу эрхийн хувьцааг компанийн хувьцаа эзэмшигчид худалдан авах эрхийг тодорхойлох, давуу эрхийн хувьцааны хэлбэр, давуу эрхийн хувьцааны зорилго, давуу эрхийн хувьцааны зарцуулалтын зориулалт, давуу эрхийн хувьцааны саналын эрх, давуу эрхийн хувьцааны нөхцөл, давуу эрхийн хувьцааг компанид эргүүлэх худалдах үнэ, давуу эрхийн хувьцааны хугацаа, давуу эрхийн хувьцааны ногдол ашиг, давуу эрхийн хувьцааны ногдол ашиг олгох нөхцөл, давуу эрхийн хувьцааны татан буулгалтын үнийг тус тус тогтоох эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг компанийн ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

**“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 09 сарын 30-ны өдөр

№ 05/25


Улаанбаатар хот

Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 3 дугаар хэсгийн 3.13.1 дэх заалт болон 2025 оны 09 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны чиглэл нэмэгдүүлсэнтэй холбогдуулан дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хүргүүлж, зохих бүртгэлийг хийлгэх ажлыг удирдан зохион байгуулах, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг компанийн гүйцэтгэх захирал Б.Лхагвадорж-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/